

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2014 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ, АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ИЛ ТОД БАЙДЛЫГ
ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

2014.11.14

Улаанбаатар хот

№	Зорилтууд	Хийж хэрэгжүүлэх ажил	Биелэлт	Тайлбар ⁱ
1	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг харьяа орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулна.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2014 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, 2014 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 1/432 тоотойр Авлигатай тэмцэх газарт, 2014 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/609 тоотойр орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлэн ажилласан.	7.2.1.
		Орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллага тус бүрээр нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гаргуулан хэрэгжилтийг хангуулж, үр дүнг тооцно.	Орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллага тус бүрээр нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гаргуулан хэрэгжилтийг хангуулж, үр дүнг тооцно. -Дүгнэлт: Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлснээс ил тод байдал хангагдаж, авлига үүсэх нөхцөл боломжийг хааж байгаагаараа давуу талыг үзүүлж байна. -Хүндрэл бэрхшээл: Улс орны эдийн засаг уналтад орж байгаатай холбогдуулан Засгийн газраас урсгал зардлыг бууруулж байгаа, нэмж төсөвлөхгүй байгаа зэрэг нь төлөвлөсөн ажлыг хэрэгжүүлэхэд хүндрэлийг бий болгож байна. -Цаашид авах арга хэмжээ: Эрх бүхий албан тушаалтны орон тоог 500-аас дээш ажилтантай байгууллага бүрт шинээр бий болгох санлыг Авлигатай тэмцэх газраас УИХ-д тавьж нэгдсэн журмаар шийдвэрлүүлэх.	7.2.1
2	Ухаалаг төрийн зарчмыг нэвтрүүлж, хяналт шалгалтын ил тод байдлыг	Мэргэжлийн хяналтын байгууллагад ухаалаг төрийн зарчмыг нэвтрүүлэх талаар хэлэлцүүлэг явуулж, хэлэлцүүлгээс гаргасан саналыг үндэслэн системийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас “Ухаалаг төрийн зарчим” хэлэлцүүлгийг 2014 оны 02 дугаар сарын 18-наас 28-ны хооронд системийн хэмжээнд зохион байгуулав. Хэлэлцүүлэгт НМХГ, 21 аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Замын-Үүд, Сүхбаатар, Буянт-Ухаа боомт дахь	МХЕГ ⁱⁱ

<p>хангаж, хөнгөвчилнө.</p>	<p>төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллана. Төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар удирдах дээд байгууллага, олон нийтэд тайлагнаж мэдээлнэ.</p>	<p>Хилийн мэргэжлийн хяналтын албаны нийт 1200 улсын байцаагч, албан хаагчид оролцсон. Хэлэлцүүлгээс гарсан санал болон улсын байцаагч нартай хийсэн уулзалт ярилцлага, “Мэргэжлийн хяналтын шинэчлэл-Миний оролцоо” сэдэвт эссэ бичлэгийн уралдаанд ирүүлсэн санал зэргийг судлан, тэдгээрт тулгуурлан Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд “Ухаалаг төрийн зарчим”-ыг нэвтрүүлэх зорилт, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж МХЕГ-ын даргын 2014 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 158 тоот тушаалаар баталлаа. Энэхүү зорилт, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд аймаг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Хилийн мэргэжлийн хяналтын албад тодорхой арга хэмжээг улирал, сарын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж, үр дүнг хагас, бүтэн жилээр тайлагнаж байхаар удирдамж чиглэл өгөн ажиллаж байна.</p>	
	<p>Мэргэжлийн хяналтын байгууллагын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулан батлаж, зохион байгуулалтыг өөрчилнө.</p>	<p>МХЕГ-ын даргын 2014 оны 284 дүгээр тушаалаар төв аппаратын, 295 дугаар тушаалаар нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын, 313, 314 дүгээр тушаалаар аймгуудын Мэргэжлийн хяналтын газар, хилийн Мэргэжлийн хяналтын албадын бүтэц, орон тоог шинэчлэн баталж, зохион байгуулалтын холбогдох арга хэмжээ авсан. Энэхүү бүтэц, орон тооны өөрчлөлтийг МХЕГ-ын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын санал, Төсвийн тухай хуулиар батлагдсан орон тоонд үндэслэн баталсан бөгөөд орон нутагт нэн шаардлагатай орон тоог нэмэгдүүлж, цаашид үргэлжүүлэн ажиллуулах шаардлагагүй, ачаалал багатай орон тоог цөөрүүлж төрийн үйлчилгээг чанаржуулснаараа онцлогтой.</p>	<p>МХЕГ</p>
	<p>Мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх арга хэмжээ авна.</p>	<p>“МХЕГ-ын Эрсдэлийн удирдлагын стратеги”-ийг боловсруулж Монгол Улсын Шадар сайдаар батлуулахаар хүргүүлсэн. Тус стратегийг нэвтрүүлэхэд нэгдсэн бодлого, аргазүйгээр ханган ажиллах “Эрсдэлийн удирдлагын газар”-ыг байгуулах хэрэгцээ, шаардлага, бүтцийн танилцуулгыг боловсруулан тушаалын төслийн хамт Шадар сайдад хүргүүлсэн. Эрсдэлийн удирдлагын олон улсын ISO31000</p>	<p>7.1.3 МХЕГ</p>

			<p>стандартыг байгууллага даяараа нэвтрүүлэх зорилгоор Олон улсын санхүүгийн корпорацийн зөвлөхүүдийг урьж МХБ-ын 1400 удирдлага, улсын байцаагчдад 3 шатны сургалт, уулзалт зохион байгуулж нэгдсэн ойлголттой болгох арга хэмжээ авлаа. 2010 оноос эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн үр дүнд дүн шинжилгээ хийж 2015 оны төлөвлөлт хийх бэлтгэл ажлыг хангаж байна.</p>	
		<p>Хилийн хяналтын удирдлага, зохицуулалтыг оновчтой болгон, эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.</p>	<p>“Импортын барааны эрсдэлийг тодорхойлох шалгуур, үзүүлэлт”¹-ийг Засгийн газрын 2014 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар батлуулсан. Хилээр нэвтэрч байгаа бараа, бүтээгдэхүүнд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлж мэргэжлийн хяналтад хамрагдах их, дунд, бага эрсдэлтэй импортын барааны жагсаалтыг Шадар сайдын 2014 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 60 тоот тушаалаар батлуулсан.</p> <p>Импортын барааны эрсдэлийг тооцох ерөнхий шалгуур, үзүүлэлтээр БТКУС-ийн 8 орны түвшинд кодлогдсон импортын нийт 5744 барааг хүн, мал, амьтны эрүүл мэнд, ургамал, хүрээлэн буй орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болох хор хөнөөл, үр дагаврын хэмжээг үнэлж, бага, дунд, их эрсдэлтэй гэж ангилсан. Бага эрсдэлтэй үнэлэгдсэн 3550 барааг хяналт шалгалтаас чөлөөлж, дунд, их эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 2194 барааг хилийн мэргэжлийн хяналтад хамруулж, төлөв тогтоох шалгуур, үзүүлэлтээр үнэлэн хяналт шалгалт хийж байна. Бага эрсдэлтэй 193 импортын барааг лабораторийн шинжилгээ, биет үзлэгээс чөлөөлж, дунд эрсдэлтэй 643 импортын барааг лабораторийн шинжилгээнээс чөлөөлсөн.</p> <p>Хилийн мэргэжлийн хяналтад хамрагдах барааны жагсаалтыг тодорхой болгосноор импортын бүх бараанд хяналт шалгалт хийж, дээж авч буй одоогийн тогтолцоог шинэчлэн эрсдэлтэй бараанд хяналт хийх, эрсдэл багатай барааг хяналтаас чөлөөлөх, гадаад худалдааг хөнгөвчлөх эрх зүйн орчин бүрдээд байна. Энэ нь хил дээр ажиллаж байгаа байцаагчийн ажлын ачаалал буурахад мөн эерэгээр нөлөөлж байна.</p>	<p>7.1.3 МХЕГ</p>

	<p>Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн эрсдэл их үнэлэгдсэн объектуудад хяналт шалгалтыг хийнэ.</p>	<p>Засгийн газрын 2012 оны 23 тоот тушаалаар баталсан эрсдэлийн шалгуур, үзүүлэлтээр 2014 онд давхардсан тоогоор 65923 объект эрсдэлийн үнэлгээнд хамрагдаж 11475 /17,4%/ их эрсдэлтэй үнэлэгдсэн. Эдгээр их эрсдэлтэй объектын эрсдэлийг бууруулж аюулгүй байдлыг хангах үүднээс төлөвлөгөөт шалгалт хийх объектын тоо, нэрийг Шадар сайдаар батлуулан олон нийтэд зарласны дараа хийдэг. Төлөвлөгөөт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу заавал удирдамж, хяналтын хуудастай хийдэг. Үүний хэрэгжилтэд тус газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс, Эрсдэлийн удирдлагын багаас хяналтын хуудасны нэгдсэн санд ирүүлсэн байцагч бүрийн мэдээллээр хяналт тавьж ажилладаг. Нийт 170 хяналтын хуудсыг жил бүр боловсронгуй болгож МХЕГ-ын даргын тушаалаар батлуулан МХЕГ-ын inspection.gov.mn/хяналт_шалгалт/ хяналтын хуудас хэсэгт байршуулж ААНБ-д ил тод үнэ төлбөргүй хүргэж байна.</p>	7.1.3 МХЕГ
	<p>2014 онд хяналт шалгалтад хамрагдах 11910 объектын нэрсийг нийтэд зарлаж, хяналт шалгалтыг гүйцэтгэнэ.</p>	<p>Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2014 онд төлөвлөгөөт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх объектын нэрсийг аймаг, нийслэлээр гаргаж МХЕГ-ын inspection.gov.mn/хяналт_шалгалт/ хяналт шалгалтын төлөвлөгөө хэсэгт өмнөх оны 12-р сарын 1-ны дотор ил тод байршуулж хэвшсэн. Объект бүрд шалгалт хийхээс 3-5 хоногийн өмнө мэдэгдэх хуудсаар эсвэл утсаар заавал мэдэгддэг.</p>	7.1.3 МХЕГ
	<p>Шалгалтад хамрагдсан байгууллага, аж ахуйн нэгжийн нийт ажилтнуудад нэг өдрийн сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.</p>	<p>Төлөвлөгөөт шалгалтын дараа тухайн байгууллагын үйл ажиллагаанд илэрсэн зөрчил дутагдал, үүсэх эрсдэлийг бууруулах чиглэлээр байгууллагын сургалтын хөтөлбөрийн дагуу хийж хэвшсэн. Байгууллагын сургалт хийх 11910 байгууллагын нэрийг Шадар сайд баталж, хэрэгжилтэд тус газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Эрсдэлийн удирдлагын багаас хяналт тавин ажиллаж байна.</p>	7.1.3 МХЕГ
	<p>Тодорхой салбар, чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийг хамруулан салбарын сургалтыг зохион байгуулна.</p>	<p>2014 онд 32 салбар, чиглэлээр бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд сургалт хийхээр төлөвлөгдсөнөөс байгаль орчин, геологи, уул уурхайн чиглэлийн 2, дэд бүтцийн чиглэлийн 4, эрүүл мэнд, эм, биобэлдмэлийн чиглэлийн 7, хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр үйлчилгээний чиглэлийн 3,</p>	7.1.3 МХЕГ

			хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлийн 1, хилийн хяналтын чиглэлийн 2 сургалтыг тус тус зохион байгуулж арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Үлдсэн 13 сургалтын 12 сургалтыг 2014 оны 11, 12 сард зохион байгуулах бөгөөд “Засгийн газрын тусгай сангуудын захиран зарцуулалтын журам” батлагдаагүйтэй холбогдуулан 1 сургалтыг зохион байгуулах боломжгүй болсон. /жишээ болгож Монголын үйлдвэрчний эвлэлтэй хамтран зохион байгуулсан сургалтын хөтөлбөрийг хавсаргав./	
		Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр олон нийтэд зарлагдсан объектуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ. Зөвлөн туслах үйлчилгээг хяналт шалгалтын хэлбэрээр бус, мэдээлэл өгөх, мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх хэлбэрээр хэрэгжүүлнэ.	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх объектын нэрс, тоог жилийн өмнө Шадар сайд баталдаг. Тус газрын Эрсдэлийн удирдлагын багаас зөвлөн туслах үйлчилгээг шалгалтын бус хэлбэрээр өгч байгаа эсэхэд тандалт судалгаа хийж, хяналт тавин ажиллаж байна. Судалгааг Хэнтий, Дорнод аймаг, нийслэлийн 6 дүүргийн ААНБ-д хэрэгжүүлсэн. Судалгааны асуулгын дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа нэмэгдэж, бизнесийн орчинд таатай нөхцөл бүрдсэн талаарх талархлаа бизнес эрхлэгчид ихээр илэрхийлсэн нь үр дүнтэй ажил болж байгааг харуулж байна.	7.1.3 МХЕГ
		Эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах арга замыг тодорхойлох, зөрчил дутагдлын шалтгаан нөхцөлийг тогтоох зорилгоор мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийнэ.	Төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын хэмжээнд хийх 31 чиглэлийн 12 тандалт судалгааны ажлын удирдамжийг боловсруулан батлуулж, орон нутагт хүргүүлсэн бөгөөд удирдамжийн дагуу тандалт судалгааны ажлууд хийгдэж байна.	7.1.3 МХЕГ
		Байгууллагын үйл ажиллагаа, хяналтын ажлын үр дүнг олон нийтэд сурталчлан таниулах олон хэлбэрийн арга хэмжээг зохион байгуулна.	ТВ-9 телевизтэй хамтын гэрээ байгуулан хамтран ажиллаж, иргэд, ААНБ-уудад хяналтын чиглэл, салбар бүрээр мэдээлэл, мэдлэг өгдөг “Мэргэжлийн хяналтын цаг” нэвтрүүлгийг долоо хоног тутамд хүргэж байна. Өнөөдрийн байдлаар 34 удаагийн нэвтрүүлгийг үзэгчдэд хүргэсэн. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтын газар, хэлтсүүдээс олон нийтэд хүргэх зөвлөмж, сэрэмжлүүлэг материалыг байгууллагын вэб хуудас, фэйсбүүк хуудсаар дамжуулан түгээж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 31 материалыг байгууллагын вэб сайтад байршуулаад байна.	7.1.1. 7.2.3.

			<p>Түүнчлэн Мэргэжлийн хяналтын ажилтны өдрийг тохиолдуулан 50 нүүр бүхий “Түмний төлөө төрийн хяналт” мэдээлэл, зөвлөмж, танин мэдэхүйн сэтгүүлийг бэлтгэн гаргасан.</p> <p>Вэб сайтад цаг үе, үйл явдлын 218 мэдээ, хяналт шалгалтын 38 мэдээ, 29 зөвлөмж, сэрэмжлүүлэг нийтэлж, өдөр тутмын сонинд нийтлэгдсэн мэдээ материалаас 85 мэдээллийг сонгон, хэвлэлийн тойм буланд байршуулав. Фото болон видео материалыг байгууллагын Facebook, Youtube хуудсаар дамжуулан түгээж байна.</p> <p>Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлыг олон нийтэд нээлттэй нэвтрүүлснээс гадна Хэвлэлийн хурал болон цаг үеийн бусад асуудлуудаар сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагуудад мэдээллийг хэвлэмэл, онлайн хэлбэрүүдээр түгээж, байгууллагын вэб сайтад тухай бүрт нь байршуулж байна. Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2014 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 1750 удаа хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээлэл өгсөн дүнтэй байна.</p>	
		<p>Мэдээллийн технологийн дэвшлийг хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.</p>	<p>Бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжид хүндрэл чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчлэх, улсын байцаагчийн нөлөөллийг багасгах үүднээс Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт шалгалтын /IMS/ системийн дэд модулиуд болох Хилийн мэргэжлийн хяналтын программыг Гаалийн ерөнхий газартай хамтран боловсруулж байна.</p> <p>Төсөв хэмнэх, мэдээллийг түргэн шуурхай солилцох зорилгоор Хүнсний бүртгэлийн мэдээллийн системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэглэж Цахим хурлын “Zoom” программ хангамжийг 2014 оны 1-р сарын 10-20-ны хооронд 21 аймаг, хилийн 6 боомт, нэгдсэн төв лаборатори зэрэг нийт 28 салбар нэгжид суурилуулж 14 хоног тутамд онлайн хурал, цахим сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. Түүнчлэн Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Able Cloud дотоод удирдлагын системд МХЕГ-ыг нэг хэрэглэгч болгон үүсгэж, уг хэрэглэгчээр дамжуулан Шадар сайдын ажлын алба болон ЗГХЭГ зэрэг төрийн байгууллагуудтай онлайн</p>	7.2.3.

			албан хэрэг хөтлөлтийн программаар холбогдон мэдээлэл солилцож байна.	
		Мэргэжлийн хяналтын байгууллагын бодлогын зорилт, үйл ажиллагаа, үр дүнд хяналт шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж өгч, гүйцэтгэл, үр дүнг хангуулна.	Мэргэжлийн хяналтын төв, орон нутгийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулах талаар цаашид авах арга хэмжээний санал боловсруулах зорилгоор тэдгээрийн 2014 оны үр дүнгийн гэрээний эхний хагас жилийн биелэлт болон хууль тогтоомж, Улсын их хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Мэргэжлийн хяналтын байгууллагаас хариуцан хэрэгжүүлэхээр заасан заалтуудын биелэлт нь хүлээгдэж байгаа үр дүнд хүрч байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж тайланг нэгтгэн боловсруулан дүнг тус газрын даргын зөвлөлийн 2014 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн. МХЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 2014.03.06-ны өдрийн 01/58 тоот удирдамжийн дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын төв аппаратын хяналтын 6 газар, Тамгын газрын ажилтнуудын үр дүнгийн гэрээний биелэлтийн явц байдал, ажлын цаг ашиглалт, цалингийн балансыг үндэслэж цалин бодсон байдал, Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн болон газрын даргын зөвлөлийн хурал, шуурхай зөвлөлгөөнөөс өгөдсөн үүрэг даалгаврын биелэлт, ажлын ачаалалд хяналт шалгалт хийж, шалгалтын танилцуулгыг 2014.04.21-ны өдрийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Шалгалтын төлөвлөгөө, иргэдээс ирүүлсэн гомдол мэдээлэлд үндэслэн МХЕГ-ын даргын 2014 оны 01/206 01/208, 01/215 дугаар удирдамжийн дагуу нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Хэнтий, Орхон, Дархан-Уул, Баян-Өлгий, Өвөрхангай аймгийн МХГ-ын дотоод ажлын зохион байгуулалт, хүний нөөцийн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажилласан.	7.2.3
3	Хүний нөөцийн ил тод байдлыг	Мэргэжлийн хяналтын байгууллагын “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-	Мэргэжлийн хяналтын байгууллагын салбарын гол хууль болох Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг шинэчлэх	7.2.3.

<p>хангаж, олон нийтийг түүнтэй танилцах боломжийг бүрдүүлнэ. Хүний нөөцийн бодлогыг шинэчлэн мөрдүүлнэ.</p>	<p>ийг шинэчлэн боловсруулж, байгууллагын цахим хуудсанд байршуулна.</p>	<p>асуудал Улсын Их Хурлаар хэлэлцэгдэх шатандаа явж байна. Хяналтын тухай хууль батлагдсны дараагаар хуулийн агуулга, үзэл баримтлалд тулгуурлан хийгдэх Мэргэжлийн хяналтын байгууллагын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, шинэ бүтэц, орон тоонд үндэслэж байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр шинэчлэгдэх тул энэхүү ажил одоогоор хүлээгдэж байна.</p> <p>МХЕГ-ын даргын 2010 оны 164 дүгээр тушаалаар батлагдан хэрэгжиж буй Мэргэжлийн хяналтын байгууллагын Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, Сургалтын хөтөлбөр, ажилтнуудын Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг байгууллагын вэб сайтын хүний нөөцийн ил тод байдал хэсэгт байршуулсан.</p>	
	<p>Төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагад ажлын байрны шинжилгээ хийж, орон тоог бодьтой тодорхойлно.</p>	<p>Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2014 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 32 дугаар тушаалаар “Мэргэжлийн хяналтын системийн байгууллагуудын орон тоо, хүний нөөцийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх” үүрэг бүхий ажлын хэсэг томилогдон ажилласан бөгөөд ажлын хэсгийн дүгнэлтийг МХЕГ-ын даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлсэн.</p> <p>Ажлын хэсгийн зүгээс орон тоо, хүний нөөцийн судалгаа, шинжилгээ хийх зөвлөмж, судалгааны маягт, асуулга зэргийг боловсруулж төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлэх, хяналтын шалгалтын объектын тоог одоогийн орон тоотой харьцуулах, зарим албан тушаалд ажлын байрны зураг авалт хийх, ирүүлсэн мэдээ судалгааг нэгтгэн дүн шинжилгээ хийх замаар хяналт үнэлгээ хийсэн. /Холбогдох материалыг хавсаргав./</p>	7.2.3.
	<p>Улсын байцаагчдын хяналт тавих чиглэлийн нэршлийг оновчтой болгоно.</p>	<p>Хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд улсын байцаагчийн албан тушаалын нэршил бизнес эрхлэгчдэд төөрөгдөл үүсгэх, ойлгомжгүй байдлыг үүсгэдэг тул МХЕГ-ын 2012 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан улсын байцаагчийн хяналтын чиглэлд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан. Улсын байцаагчийн албан тушаалын нэршилд өөрчлөлт оруулах ажлын хэсгийг МХЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2014 оны 31 дүгээр</p>	7.2.3.

			тушаалаар томилон ажиллуулсан. Ажлын хэсгийг дүгнэлт МХЕГ-ын даргын зөвлөлийн хуралдаанаар 2 удаа хэлэлцэгдсэн боловч эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. /Холбогдох материалыг хавсаргав./	
		Сул орон тоо гарсан тохиолдолд харъяа орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын туршлагатай албан хаагчдаас карьерийн зарчим баримталж шилжүүлэн томилох бодлого баримтална.	Сул орон тоо гарсан тохиолдолд мэргэжлийн хяналтын системд ажиллаж байгаа, шилжин ажиллах хүсэлтээ өгсөн албан хаагчдаас карьерийн зарчим баримталж шилжүүлэн томилох бодлогыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас баримтлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү бодлогын хүрээнд орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагаас 6 албан тушаалтныг сул гарсан орон тоонд шилжүүлэн ажиллуулж байна. Энэхүү бодлогын хэрэгжүүлж ажиллахыг нийслэлийн мэргэжлийн хяналтын газар болон орон нутгийн МХБ-ын дарга нарт албан бичгээр үүрэг өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Үүний үр дүнд нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар Улаанбаатар хотод шилжин ажиллахыг хүссэн аймгийн МХГ-ын 18 албан тушаалтныг томилон ажиллуулсан дүнтэй байна. Энэ нь Мэргэжлийн хяналтын байгууллагад ажлын туршлагагүй, мэргэжлийн бус ажилтан орж ажиллахаас урьдчилан сэргийлэх бас нэгэн арга зам болсон. /Холбогдох материалыг хавсаргав./	7.1.6.
		Төв, орон нутгийн МХБ-ын сул орон тооны зарыг Төрийн албаны зөвлөлийн болон байгууллагын цахим хуудсанд тухай бүр байршуулна.	Төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагад гарсан сул орон тоог нутаг дэвсгэрийн харъяаллын дагуу тухайн орон нутаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлэх замаар Төрийн албаны зөвлөлийн вэб сайтаар дамжуулан нийтэд зарлаж, сул орон тоог нөхөж байна. Мэргэжлийн хяналтын байгууллагаас сул гарсан 37 орон тоонд ажилтан сонгон шалгаруулж авах хүсэлтээ Төрийн албаны зөвлөлд хүргүүлснийг www.csc.gov.mn сайтандаа байршуулж, нийтэд зарлан сонгон шалгаруулалтыг хийсэн. Хүргүүлсэн зарыг Төрийн албаны зөвлөлийн вэб сайтнаас татаж хавсаргав.	7.1.6.
		Удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын зарыг байгууллагын вэб сайт болон	Төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга, орлогч дарга, нэгжийн дарга нарын сонгон шалгаруулалтыг тус газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нийтэд зарлан явуулдаг. Тайлант хугацаанд МХЕГ-	7.1.6.

		өдөр тутам, орон даяар гардаг сонин хэвлэлээр зарлана.	ын Тамгын газрын дарга, нийслэлийн болон Булган, Дорноговь, Өмнөговь, Увс, Ховд, Хэнтий, Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Буянт-Ухаа, Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны дарга, орлогч даргын сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтуудын зарыг Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn сайтын удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын зар хэсэг болон МХЕГ-ын www.inspection.gov.mn сайтын хүний нөөцийн ил тод байдлын сул орон тооны зар хэсэгт тус тус байршуулж, орон даяар, өдөр тутам гардаг сонин хэвлэлээр давхар зарлаж, нийтэд мэдэгдсэн. /Холбогдох материалаас жишээ болгож заримыг хавсаргав./	
4	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгоно.	Төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын нийт ажилтнуудын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг ижилсүүлнэ.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 29 дүгээр тушаалаар томилогдсон ажлын хэсэг төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын нийт 115 албан тушаалын тодорхойлолтыг төв аппарат, аймаг, нийслэл, сум, дүүрэг, ХМХА, лабораторийн түвшин тус бүрээр шинээр болон шинэчлэн боловсруулсан. Энэхүү ажлын хүрээнд 569 чиглэлээр ажлын байрны тодорхойлолтын загвар хийсэн бөгөөд ажлын байрны тодорхойлолтын загварыг боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан. Үүнд: 1. Улсын байцаагчдын ажлын байрны тодорхойлолтуудыг нэг стандартад оруулах; 2. Ажил байр тус бүрээр чиг үүрэг, түүний хүрээнд хийх ажилбаруудыг илүү нарийвчлан гаргах; 3. Ажлын байрны тодорхойлолтыг төв, орон нутгийн түвшин, онцлогт тохируулан зааг ялгаатай болгох; 4. Салбаруудын хууль, эрх зүйн орчны шинэчлэл, байгууллагын бүтцийн өнөөгийн байдалтай уялдуулах; 5. Албан тушаал бүрт тавигдах мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг нэг түвшинд, илүү тодорхой болгох. Эдгээр зарчмын дагуу улсын байцаагчдын ажлын байрны тодорхойлолтыг “Бодлого тодорхойлох”, “Эрсдэлээс урьдчилан сэргийлэх”, “Хяналт шалгалт хийх”, “Орон	7.1.8

			нутгийн МХБ-ын улсын байцаагчийг арга зүйн удирдамжаар хангах”, “Авлига, хүнд суртлаас ангид байх” үндсэн 5 зорилтын хүрээнд нэг загвараар шинэчлэн боловсруулсан. Түүнчлэн захиргааны албан хаагчид болох газар, хэлтсийн дарга, дэд дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, төрийн үйлчилгээний албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан. Үүний зэрэгцээ төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын /ахлах/ байцаагчийн үйл ажиллагааны үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэх хуваарийг түвшин бүрээр ялгамжтай тогтоож өгсөн. /Холбогдох материалыг хавсаргав./	
		Тухайн ажилтны хариуцах ажил, албан тушаалын чиг үүрэг, байрлах өрөө тасалгаа, холбоо барих албаны утасны дугаарыг байгууллагын цахим хаяганд байршуулна.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, Ёс зүйн хорооны дарга, гишүүд, МХЕГ-ын даргын зөвлөлийн гишүүдийн чиг үүрэг, байрлах өрөөний дугаар, холбоо барих албаны утсыг байгууллагын вэб сайтын Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл, Ёс зүйн хороо, даргын зөвлөл хэсгээс үзэж болохоос гадна нийт ажилтнуудын албан тушаал, утасны жагсаалт зэргийг утасны жагсаалт хэсэгт байршуулсан. Түүнчлэн байгууллагын ажилтнууд, тэдгээрийн өрөөний болон утасны дугаарыг мэдээллийн самбарт байршуулж, Засгийн газрын 12 дугаар байрны хамгаалалтын албанд хүргүүлж, иргэдийг мэдээллээр шуурхай хангах арга хэмжээ авч ажиллаж байна.	7.1.8.
5	Давхар ажил эрхлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.	Улсын байцаагчийн үндсэн ажлын зэрэгцээ давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, ажилтнууд болон нийтэд мэдээллэнэ.	Улсын байцаагчийн үндсэн ажлын зэрэгцээгээр давхар ажил эрхэлж болох ажлын жагсаалтыг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу нийт ажилтнуудад танилцуулж, гарын үсэг зуруулан авсан.	7.1.12
		Давхар ажил эрхэлж буй албан тушаалтны судалгаа гаргаж, хуулиар зөвшөөрөгдсөн ажил гүйцэтгэж байгаа ажилтанд давхар ажил эрхлэх зөвшөөрлийг албан ёсоор олгоно.	Давхар ажил эрхэлж буй албан тушаалтны судалгааг төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын нийт ажилтнуудаас авсан бөгөөд тус газарт үндсэн ажлын хажуугаар давхар ажил эрхэлдэг 3 албан тушаалтан байгаа гэсэн судалгааны дүн гарсан. 2014 онд боловсролын	7.1.12

			хяналтын улсын ахлах байцаагч Л.Дэлгэрмаа давхар ажил эрхлэх хүсэлт гаргасныг хянаж үзээд холбогдох зөвшөөрлийг олгосон. /Зөвшөөрлийн хуудсыг хавсаргав./	
		Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг зөрчиж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.	Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг зөрчиж байгаа эсэхэд байнгийн хяналт тавьж ажиллах үүргийг төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын дарга нарт албан бичгээр хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	7.1.12
6	Төсвийн ил тод байдлыг хангуулна. Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээллэнэ.	2014 оны төсөв, 2013 оны төсвийн гүйцэтгэл, 2015 оны төсвийн төслийг байгууллагын вэб сайтад байршуулна.	Холбогдох мэдээллийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын www.inspection.gov.mn вэб сайтад болон мэдээллийн самбарт байршуулсан болно. Мэдээллийг вэб сайтын санхүүгийн ил тод байдал хэсгээс харж болно. Вэб сайтад тавигдсан мэдээллийг хавсаргав.	7.1.4
		Жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухайн бүр олон нийтэд мэдээллэнэ.	Холбогдох мэдээллийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын www.inspection.gov.mn вэб сайтад болон мэдээллийн самбарт байршуулсан болно. Мэдээллийг вэб сайтын санхүүгийн ил тод байдал хэсгээс харж болно. Вэб сайтад тавигдсан мэдээллийг хавсаргав.	7.1.4
		Татварын болон татварын бус төсвийн орлого бүрдүүлэлтийн нээлттэй байдлыг хангана.	Холбогдох мэдээллийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын www.inspection.gov.mn вэб сайтад болон мэдээллийн самбарт байршуулсан болно. Мэдээллийг вэб сайтын санхүүгийн ил тод байдал хэсгээс харж болно. Вэб сайтад тавигдсан мэдээллийг хавсаргав.	7.1.4
		Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсанд байршуулж, тухай бүр шинэчлэнэ.	Холбогдох мэдээллийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын www.inspection.gov.mn вэб сайтад болон мэдээллийн самбарт байршуулсан болно. Мэдээллийг вэб сайтын санхүүгийн ил тод байдал хэсгээс харж болно. Вэб сайтад тавигдсан мэдээллийг хавсаргав.	7.1.4
		Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг нээлттэй байлгана.	Холбогдох мэдээллийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын www.inspection.gov.mn вэб сайтад байршуулсан болно. Мэдээллийг вэб сайтын гадаад харилцаа хэсгээс харж болно. Вэб сайтад тавигдсан мэдээллийг хавсаргав.	7.1.4
7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.	ХААГ-ын дарга, МХЕГ-ын даргын хамтарсан тушаалаар батласан 2014 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын веб сайтад байршуулсан бөгөөд сонин хэвлэлээр мэдээллэх үүргийг Худалдан авах ажиллагааны газар хүлээдэг.	7.1.7

<p>үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангуулж, түүнтэй танилцах боломжийг бүрдүүлнэ.</p>	<p>Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулна.</p>	<p>Ховд аймгийн МХГ-ын лабораторийн барилгын тендерыг Худалдан авах ажиллагааны газраас зарласан бөгөөд тус газрын e_procurement.gov.mn сайтанд байршуулсныг үзэж болно.</p>	7.1.7
	<p>Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, мэдээллийн хэрэгслээр зарлана.</p>	<p>Ховд аймгийн МХГ-ын лабораторийн барилгын тендерыг ХААГ-т зарласан бөгөөд урилгыг өдөр тутамын e_procurement.gov.mn сайтанд байршуулсныг үзэж болно.</p>	7.1.7
	<p>Тендерт оролцохыг сонирхогч этгээдэд тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийн талаарх мэдээллийг нээлттэй байлгаж, иргэд танилцах боломжоор хангана.</p>	<p>Тендертэй холбоотой бичиг баримт, бусад мэдээлэлийг meps.gov.mn, e_procurement.gov.mn, e-tender.mn сайтуудад байршуулсныг үзэж болно.</p>	7.1.7
	<p>Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг нээлттэй байлгаж, иргэд танилцах боломжоор хангана.</p>	<p>Тендертэй холбоотой бичиг баримт, бусад мэдээлэлийг meps.gov.mn, e_procurement.gov.mn, e-tender.mn сайтуудад байршуулсныг үзэж болно.</p>	7.1.7
	<p>Тендерт оролцогчдод тендерт шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тухай бүр танилцуулна.</p>	<p>Тендертэй холбоотой бичиг баримт, бусад мэдээлэлийг meps.gov.mn, e_procurement.gov.mn, e-tender.mn сайтуудад байршуулсныг үзэж болно.</p>	7.1.7
	<p>Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг нээлттэй байлгаж, иргэд танилцах боломжоор хангана.</p>	<p>Тендертэй холбоотой бичиг баримт, бусад мэдээлэлийг meps.gov.mn, e_procurement.gov.mn, e-tender.mn сайтуудад байршуулсныг үзэж болно.</p>	7.1.7
	<p>Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлэнэ.</p>	<p>Тендер шалгаруулах явцад зөрчил илэрээгүй</p>	7.1.7
	<p>Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнгийн талаарх мэдээллийг нээлттэй байлгаж, сонирхсон этгээдийг танилцах боломжоор хангана.</p>	<p>Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнгийн талаарх мэдээллийг нээлттэй байлгаж, сонирхсон этгээдийг танилцах боломжоор хангасан.</p>	7.1.7

		Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна.	Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн барилгын тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд барилгын техникийн хяналтын улсын байцаагч, тоног төхөөрөмж хариуцсан улсын байцаагч, тендерийн сертификат бүхий Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны төлөөллийг оролцуулан үнэлгээний хороог байгуулан ажилласан. /Тушаалын хуулбарыг хавсаргав./	7.1.7
8	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулж ажиллана.	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг тодорхой судалгаа, шинжилгээнд үндэслэж гаргана.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2014 оны 32 дугаар тушаалаар байгуулагдсан Мэргэжлийн хяналтын байгууллагын орон тоо, хүний нөөцийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийсэн ажлын хэсгийн дүнг тус газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаалтныг хооронд нь сэлгүүлэх асуудлыг ярилцаж 2014 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар шийдвэрийг гаргасан. Дээрх шийдвэрээр МХЕГ, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны хилийн хяналт хариуцсан ажилтнууд, дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн ажилтнуудыг хооронд сэлгүүлэх үүргийг холбогдох байгууллагын дарга нарт өгсөн. Энэхүү шийдвэрийн дагуу НМХГ-аас 11, Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албанаас 11 нийт 22 ажилтныг хооронд нь сэлгүүлэх, дүүргүүд дэх Мэргэжлийн хяналтын хэлтэст нэг ажлын байранд 3-аас дээш жил ажилласан 151 улсын байцаагчийг дүүрэг хооронд сэлгүүлэн ажиллуулсан.	7.1.15
		Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааг дотоод хяналт шалгалтын нэгжээр тодорхой хугацааны давтамжтайгаар хянуулах механизмыг бүрдүүлнэ.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2014 оны 06 дугаар шийдвэрээр 9 дүүрэг, 6 гүний терминаль хариуцан ажилладаг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт 8 хүний бүрэлдэхүүн бүхий дотоод хяналт шалгалтын нэгжийг байгуулан ажиллуулах үүрэг өгөгдсөн. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлж МХЕГ-ын даргын 2014 оны 295 дугаар тушаалаар НМХГ-ын бүтэц, орон тоог шинэчлэн батлахдаа дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний нэгжийг шинээр байгуулан ажиллуулж байна.	7.1.15 /МХЕГ/
		Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудал илэрвэл	Авлигын эсрэг хууль тогтоомж зөрчсөн байж болзошгүй гэж үзсэн тул нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд	7.2.2.

	<p>Авлигатай тэмцэх газарт мэдээлж, шалгуулна.</p>	<p>дарга С.Даваасүрэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хилийн мэргэжлийн хяналтын газрын дарга Г.Адъяасүрэн, Эрсдэлийн үнэлгээ, удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Э.Мөнхөө, ургамал, хорио цээр, чанарын хяналтын улсын ахлах байцаагч Д.Довчинсүрэн, Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Гантулга нарыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, эрх бүхий албан тушаалтны санаачлагаар Авлигатай тэмцэх газраар шалгуулах хүсэлтийг хүргүүлж, шалгуулсан. /Холбогдох материалыг хавсаргав./</p>	
	<p>Авлигатай тэмцэх газар болон түүний холбогдох албан тушаалтнаас ирүүлсэн зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөж, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар ирүүлсэн мэдэгдэл, албан бичгийн дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллана.</p>	<p>Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас авах.</p>	
	<p>Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар, шийдвэр, үйл ажиллагааг өөрчлөх буюу хүчингүй болгоно.</p>	<p>Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар, шийдвэрт тус газрын хуулийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд судалгаа хийсэн. Одоогоор байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн дууссан бөгөөд бусад дүрэм, журмыг шинэчлэх шаардлагагүй гэж үзсэн.</p>	7.1.17
	<p>Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар мэдээллэх журмын хэрэгжилтийг хангана.</p>	<p>Сахилгын шийтгэл ногдуулсан ажилтнуудын судалгаа, мэдээллийг байгууллагын вэб сайтаар дамжуулан олон нийтэд хүргэж байна. Холбогдох материалыг хавсаргав.</p>	7.1.17
	<p>Шаардлагатай тохиолдолд Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжиж үйл ажиллагаандаа татан оролцуулна.</p>	<p>1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2014 онд 16 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсны дотор Ногоон сэтгүүлч ТББ, Медиа холдинг, Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэл, МХЕГ-ын ахмадын холбоо багтаж байна. Эдгээр төрийн бус байгууллагуудтай хэвлэл мэдээлэл, хүнсний</p>	7.1.9. 7.2.2.

			<p>аюулгүй байдал, хяналт шалгалтын чиглэлээр хамтран ажиллаж байна. Хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын вэб сайтаар тухай бүр мэдээллэсэн. Холбогдох материалыг хавсаргав.</p> <p>2. Монгол Улсад засаглал, ил тод байдлыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Америкийн Нэгдсэн Улсын Азийн сантай хамтран бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдалд Сант марал төрийн бус байгууллагаас хийсэн судалгааны талаар хэвлэлд гарсан мэдээлэлтэй танилцаад тус төрийн бус байгууллага руу хамтран ажиллах санал хүргүүлсэн. Албан бичгийн хариуд тус байгууллагаас судалгааны дүнг ирүүлж, цаашид хамтран ажиллах саналаа илэрхийлсэн байна. 2015 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа Сант марал ТББ, Азийн сантай хамтран ажиллана. Холбогдох материалыг хавсаргав.</p>	
		<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтныг ажиллуулж, гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтод тусгаж, үр дүнг тооцон ажиллана.</p>	<p>Авлигатай тэмцэх газар анх байгуулагдсан цагаас эхлэн тус газрын хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн М.Нармандахыг эрх бүхий албан тушаалтнаар томилон ажиллуулж, уг ажлыг хариуцуулан ажиллуулж байна. Түүний ажлын байрны тодорхойлолтод авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх, АТГ-тай хамтран ажиллах үүргийг оруулж, зохих үр дүнг тооцож, 30 хувийн нэмэгдлийг олгон ажиллаж байна. Тус газрын эрх бүхий албан тушаалтан нь АТГ, Нийгмийн дэвшил, эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгуулсан эрх бүхий албан тушаалтны сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдаж сертификат авсан бөгөөд АТГ-аас зохион байгуулсан сургалтуудад бүрэн хамрагдаж ирсэн. ЭБАТ-ны үйл ажиллагааг АТГ-аас үнэлсэн. Холбогдох материалыг хавсаргав.</p>	7.1.10
9	<p>Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод, нээлттэй,</p>	<p>Хяналтын тухай хуулийн төслийг цахим хуудсанд байршуулж, иргэд, олон нийтийн саналыг тусгана.</p>	<p>1/УИХ, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж байгаа “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд УИХ-ын ТББХ, МХЕГ, Төв аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран 2014 оны 05 дугаар сарын 14-ны өдөр Төв аймгийн Зуунмод суманд “Хяналтын тухай хуулийн төсөл”-өөр иргэд, төрийн болон</p>	7.1.2

<p>хүртээмжтэй байдлыг хангуулна.</p>		<p>төрийн бус байгууллагуудын албан хаагчдыг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Энэ хэлэлцүүлэгийн хүрээнд: а/ Төв аймгийн иргэний танхимд хуулийн төслийг иргэд танилцуулж, санал авах ажиллагааг зохион байгуулсан. б/Хуулийн төслийн хэлэлцүүлэг эхлэхээс өмнө Өдөр тутмын сонин болох “Өнөөдөр” сонинд хуулийн төслийг нийтэлсэн ба мөн хуулийн төслийг 200 хувь хувилж иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд тарааж танилцах боломжийг олгосон. Хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга А.Бакей, Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагва, УИХ-ын гишүүн Су.Батболд, С.Ганбаатар, Шадар сайдын зөвлөх Ж.Батсуурь, Төв аймгийн ИТХ-ын дарга Ц.Мэндсайхан, Засаг дарга Д.Баярбат нар болон Төв аймгийн иргэд, бизнесийн байгууллагын болон төрийн байгууллагын төлөөлөл нийт 150 орчим иргэд оролцсон.</p> <p>2/ Хяналтын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их хурлын гишүүн Г.Батхүүгийн өгсөн үүрэг даалгаврын дагуу тус хуулийн төсөлд иргэд болон мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчдаас санал авах ажлыг 2014 оны 07 дугаар сарын 22-оос 08 дугаар сарын 08-ны хооронд улсын хэмжээнд буюу 21 аймаг, нийслэлийн МХГ болон Буянт-Ухаа, Замын-Үүд, Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албадаар хийлгүүлж, дүнг нэгтгэн гаргасан. Иргэд болон мэргэжлийн хяналтын байцаагч, албан хаагчдыг цахим хэлбэр (байгууллагын www.inspection.gov.mn веб сайт, фейсбүүк, й-мейл)-ээр, 1800-1286 нээлттэй утсаар, саналын хайрцагаар, бичгээр болон амаар саналаа өгөх боломжийг орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагууд бүрдүүлж ажиллав.</p> <p>Мөн Хяналтын тухай хуулийн төсөлд санал авах үйл ажиллагааг зохион байгуулж байгаа талаарх зар мэдээллийг орон нутгийн телевиз, радио, сонин, Иргэний танхим зэрэг хэвлэл, зарлал мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэснээс гадна хуулийн төсөлд санал өгөх хүсэлт албан бичгийг төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж,</p>
---------------------------------------	--	--

байгууллагуудад хүргүүлж оролцоог хангах арга хэмжээ авч ажилласан. Хуулийн төсөлд нийтдээ 2234 иргэн санал өгсөн бөгөөд 1466 нь хуулийн төслийг бүхэлд нь дэмжээгүй, 427 нь хуулийн төслийг дэмжсэн байна. Мөн 244 иргэн хуулийн төсөлд тусгайлан санал өгч, 97 нь тодорхой саналгүй гэдгээ илэрхийлсэн байна. Мэргэжлийн хяналтын байгууллагын 528 албан хаагч хуулийн төсөлд санал өгсний 11.8 хувь нь хуулийн төслийг дэмжээгүй байна. Харин 88.2 нь дэмжиж, хуулийн төсөлд тусгайлсан санал өгсөн.

Иргэд болон мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчдаас давхардсан тоогоор 8215 тусгайлсан санал өгсөн байна. Агуулгаар авч үзэхэд, эдгээр саналын 16.2% нь хуулийн төслийн зарим, зүйл заалтыг хасах, 65.7% нь хуулийн заалтыг өөрчлөн найруулах, 18.1 % нь хуулийн төсөлд нэмж асуудал тусгах зарчмын санал байна. Хуулийн төсөлд тусгайлан өгсөн саналын нэгтгэлийг хүснэгтээр хавсаргав.

3/ Хяналтын тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэх ажлын хэсгийн дарга, УИХ-ын гишүүн Г.Батхүүгээс нийслэл, 21 аймгийн ИТХ-д Хяналтын тухай хуулийн төслөөр хэлэлцүүлэг зохион байгуулж, тухайн орон нутгийн иргэд аж ахуйн нэгж байгууллагаас санал авч ирүүлэх талаар хүсэлт явуулсны дагуу хуулийн төслөөр хэлэлцүүлэг санал асуулга авах ажлыг зохион байгуулж, 16 аймаг, нийслэлээс нийт 460 /давхардсан/ санал ирүүлснийг нэгтгээд байна.

Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас Хяналтын тухай хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлгийг 2014 оны 9 дүгээр сар 29-ний өдөр Нийслэлийн Иргэний танхимд зохион байгуулсан. Хуулийн төслийн хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга А.Бакей, УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Г.Батхүү, НИТХ-ын дарга, хэлэлцүүлгийн модератор Д.Баттулга, МХЕГ-ын дарга Д.Батмөнх, Шадар сайдын зөвлөх Н.Батсуурь нар болон ажлын хэсгийн гишүүд, нийслэлийн байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл бүхий 100 орчим иргэн оролцсон.

		4/Хуулийн төслийн ажлын дэд хэсгийн хуралдааныг Төрийн ордонд 2014.10.08-ны өдөр зохион байгуулсан. Хуралд УИХ-ын гишүүн ажлын хэсгийн дарга Г.Батхүү, Ж.Батсуурь болон ажлын дэд хэсгийн гишүүдээс гадна Олон улсын санхүүгийн корпораци, бусад төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллүүдийг хуралд оролцуулж, санал бодлыг нь сонссон. Хяналтын тухай хуулийн төсөл, түүний танилцуулга, холбогдох байнгын хорооны дүгнэлт, дагалдах 84 хуулийн төслийг www.parliament.mn , www.inspection.gov.mn вэб сайтуудад байршуулж, иргэдийн саналыг авч байна. Хуулийн төсөлд иргэн, байгууллагаас авсан саналын нэгтгэл 94 хуудас болсон тул хэвлэн хүргүүлэх боломжгүй байна. Шаардлагатай тохиолдолд МХЕГ-т ирж үзэж болно.	
	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцоно.	Хяналтын тухай хуулийн төсөлд иргэдээс дээрх байдлаар санал авсан. Харин Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2014 онд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргаагүй болно.	7.1.2
	Байгууллага, албан тушаалтны шийдвэрийн нэгдсэн санг бүрдүүлж, нээлттэй болгон бүртгэл хяналтыг сайжруулна.	Мөн иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад хамаарал бүхий газрын даргын тушаал, тушаалаар батлагдсан журам, заавар, хяналт шалгалтын хуудас, Улсын ерөнхий байцаагчийн албан даалгавар, даргын зөвлөлийн хурлын шийдвэрүүдийг тухай бүр байгууллагын веб хуудасд байршуулж байна. Холбогдох материалыг хавсаргав.	7.1.13
	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг иргэдэд нээлттэй байдлаар байршуулна.	Газрын даргын тушаалаар батлагдсан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ бүхий журмуудыг байгууллагын веб хуудасд байршуулсан. Холбогдох материалыг хавсаргав.	7.1.13
	Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн талаарх мэдээллийг ил тод мэдээллэнэ.	Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамж, зөвшөөрөл, дүгнэлтийн талаарх мэдээллийг байгууллагын вэб сайтад болон мэдээллийн самбарт байршуулсан. Холбогдох материалыг хавсаргав.	7.1.13 7.1.5.
	Авлигын эсрэг хууль тогтоомж болон салбар хяналтын чиглэлийн хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд	-Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах хүрээнд Авлигатай тэмцэх газраас хийсэн шторкийг нээлттэй хэлэлцүүлэг, сургалт, тэмцээний үеэр нэвтрүүлснээс гадна холбогдох вэб сайтуудыг байгууллагын вэб сайтад	7.1.1. 7.2.3.

	<p>сурталчилах тусгайлсан төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.</p>	<p>байршуулан ажиллаж байна. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьчилан сэргийлэх тухай хуулийг сурталчилж, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг бөглөх аргачлал, хориглолт, хязгаарлалт, мэдэгдэл гаргах аргачлалын талаар төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтнуудад Авлигатай тэмцэх газартай хамтран их, бага хэмжээний 36 сургалтыг зохион байгуулсан. Түүнчлэн тус газарт улсын байцаагчаар шинээр томилогдсон ажилтнуудад зориулсан “Шинэ байцаагч” модульт сургалтын хөтөлбөрт авлигын эсрэг хууль тогтоомжоор семинар орж, центавр тэмцээнийг зохион байгууллаа. Хамгийн сүүлд Авлигатай тэмцэх газартай хамтран Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын орон нутагт дахь салбарыг 27 эрх бүхий албан тушаалтанд онлайн сургалт, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын нийт улсын байцаагч нарт Тэнгис кино театрын танхимд нэгдсэн сургалтыг зохион байгуулсан. Холбогдох материалыг хавсаргав. - МХЕГ-ын ажилтнуудад АТГ-аас тусгайлсан тараах материал өгөөгүй болно.</p>	
	<p>Байгууллагын вэб сайтыг шинэчилж, иргэд, олон нийтэд шаардлагатай мэдээллээр тасралтгүй баяжуулна.</p>	<p>Байгууллагын вэб сайт, түүний дизайныг 2014 онд бүрэн шинэчилж, баяжуулсан.</p>	<p>7.1.1. /МХЕГ/</p>
	<p>Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой, хамтран ажилладаг байгууллагуудын цахим хуудсыг өөрийн вэб сайтад холбож иргэдийг цогц мэдээллээр хангах боломжийг бүрдүүлнэ.</p>	<p>Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын www.inspection.gov.mn вэб сайттай Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Авлигатай тэмцэх газар, нийслэл, 21 аймгийн Мэргэжлийн хяналтын газар, олон улсын хилийн боомтууд дахь Мэргэжлийн хяналтын алба, Хүний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн вэб сайтыг холбож, иргэд, ажилтнуудыг цогц мэдээллээр хангаж байна.</p>	<p>7.1.1.</p>

		Салбар, чиглэлийн хууль тогтоомжийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагад ойлгомжтой хэлбэрээр сурталчлах, тараах материал, зурагт хуудас хэлбэрээр тараана.	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хяналтын нэгжүүдээс үйл ажиллагаандаа мөрдлөгө болгодог салбар, чиглэлийн хууль тогтоомжийг тухайн нэгжийн мэдээллийг агуулсан байгууллагын вэб сайтын холбогдох хэсэгт бүрэн байршуулж ажиллаж байна. Түүнчлэн аж ахуйн нэгж байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт, семинар, зөвлөн туслах үйлчилгээний үеэр тухайн салбарын хууль тогтоомж, дүрэм журам, зурагт хуудсыг тараах арга хэмжээнүүдийг авсан. /холбогдох материалыг хавсаргав./	7.1.1
10	Улсын байцаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд онцгой анхаарч ажиллана.	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.	-Төв, орон нутгийн МХБ-уудын Ёс зүйн хороод жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулан ажиллаж байгаа бөгөөд МХЕГ-ын Ёс зүйн хороо 2014 онд 3 чиглэлээр 11 ажил хийхээр төлөвлөж, 82%-ийн биелэлттэй байна. Төлөвлөгөөний биелэлтийг дараа дараагийн хүснэгтүүдэд нарийвчлан бичлээ. -Төв, орон нутгийн МХБ-уудын Ёс зүйн хороод жилийн үйл ажиллагааны үр дүнд Булган, Агуйдуйд, Аойааюу, Чаадай, Нүдөөдөөд, Аийдуй, Аауй-аеае, Айдий, Ооаае, Ойиде, Оо аймгийн МХГ-ууд, Буянт-Ухаа, Сүхбаатар боомт дахь ХМХА-дын улсын байцаагчид 2014 онд ёс зүйн зөрчил гаргаагүй бөгөөд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас улсын байцаагчдын ёс зүйтэй холбоотой ирүүлсэн гомдлын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20-иод хувиар буурсан байна.	7.1.11 7.2.3.
		Байгууллагын ажлын үр дүнг үнэлэх журамд ажилтнуудын гаргасан ёс зүйн зөрчлийг нэг шалгуур үзүүлэлт болгон тусгаж, хэрэгжүүлнэ	МХЕГ-ын даргын 2014 оны 04 сарын 14-ний өдрийн 160-р тушаалаар батлагдсан “Юдуйеёеёй дуйаёдуй байгууллагын үеё аеёёаааааа дуйаёд-өёёеёауу, үнэлгээ ёёё ёббай”-д Мэргэжлийн хяналтын төв, орон нутгийн байгууллага, нэгжийн үйл ажиллагааг дүгнэхдээ “Ажилтнуудын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зохион байгуулсан ажлын үр дүн”-г тухайн байгууллага, нэгжийн үйл ажиллагааг дүгнэх нэг шалгуур үзүүлэлт болгон тусгаж, хэрэгжүүлж байна.	7.2.3.
		Авлигаас ангид байх, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх сарын аяныг Мэргэжлийн хяналтын байгууллагын	“Сахилга, хариуцлагыг сайжруулах сарын аян зохион байгуулах тухай” МХЕГ-ын даргын тушаал, түүний хэрэгжилтийг хангах ажлын удирдамжийг боловсруулан МХЕГ-ын даргын 2014 оны 44 дугаар тушаалаар батлуулж,	7.2.3. 7.1.11

	<p>системийн хэмжээнд зохион байгуулна.</p>	<p>төв орон нутгийн МХБ-уудад газрын даргын 2014 оны 01 сарын 29-ний өдрийн 1/264 тоот албан бичгээр хүргүүлсэн. -“Сахилга, хариуцлагыг дээшлүүлэх сарын аян”-ны хүрээнд “Авилагагүй, хүнд сурталгүй, ёс зүйтэй хамт олныг төлөвшүүлэх” тухай улсын ерөнхий байцаагчийн мэдэгдлийг нийт ажилтнуудад танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулсан. -МХЕГ-ын ажилтнуудын ёс зүйн дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газартай хамтран Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн мэдлэгийг сорих “Цэнтавр” тэмцээнийг 2014 оны 02 сарын 27-ны өдөр зохион байгууллаа. -Сахилга хариуцлагыг дээшлүүлэх” сарын аяны хүрээнд улсын байцаагчдын ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэх нь сэдвээр тус газрын Ёс зүйн хорооны дарга Л.Энхбаяр TV-9 телевизэд ярилцлага өгч, иргэдийн сонирхсон асуултанд хариулт өгсөн.</p>	
	<p>“Мэргэжлийн хяналтын улсын байцаагчдын ёс зүйг хэрхэн дээшлүүлэх талаарх Таны санал” олон нийтийн дунд санал асуулга явуулна.</p>	<p>“Сахилга, хариуцлагыг дээшлүүлэх сарын аян-ны хүрээнд улсын байцаагчдын үйл ажиллагаа ёс зүй, хариуцлагын талаар санал авах зорилгоор 7 төрийн бус байгууллагад газрын даргын 2014 оны 02 сарын 25-ны өдрийн 1/493 тоотыг хүргүүлснээс гадна иргэдээс байгууллагын веб сайтаар цахим хэлбэрээр санал, асуулга авсан.</p>	<p>7.2.3. 7.1.11</p>
	<p>5.МХЕГ-ын Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу ХМОНХХ-тэй хамтран МХЕГ-ын төрийн захиргааны албан хаагчдад “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүй”, “Харилцааны соёл” сэдвээр сургалт зохион байгуулна</p>	<p>МХЕГ-ын Ёс зүйн хорооноос төв, орон нутгийн МХБ-уудын барилгын техникийн хяналтын улсын байцаагчдад зориулсан сургалт, “Шинэ улсын байцаагч” Online” сургалт, Өвөрхангай аймгийн МХГ, НМХГ-ын Хан-Уул дүүрэг дэх МХХ, Баян-Өлгий аймгийн МХГ-ын ажилтнуудад “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүй, “Мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтнуудын үйл ажиллагаанд хэвшүүлэх хэм хэмжээнүүд” сэдвээр илтгэл тавьж, зөвлөгөө өглөө. Сургалтад нийт 200 гаруй ажилтан хамрагдав. Түүнчлэн Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нарт зориулсан сургалтад ёс зүйн асуудлаар семнир орсон.</p>	<p>7.1.11 7.2.3.</p>

		Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалган шийдвэрлэж, ёс зүйн зөрчлийг бүртгэж, байгууллагын веб сайтад кодоор мэдээлнэ	МХЕГ-ын Ёс зүйн хороонд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчдын ёс зүйтэй холбоотой ирүүлсэн нийт 9 өргөдөл, гомдлын 5-ыг шалгаж, холбогдох хариуг гомдол гаргагчдад хүргүүлсэн бөгөөд 4 өргөдлийг харъяаллын дагуу холбогдох аймгийн МХГ-ын ЁЗХ-гоор шалгуулж, хариуг өгүүлэхээр шилжүүлсэн. -МХЕГ-ын Ёс зүйн хорооноос Өвөрхангай аймгийн МХГ-ын дарга Х.Мөнхбат, МХЕГ-ын СХНХХГ-ын улсын ахлах байцаагч улсын ахлах байцаагч Б.Довдонбалжир, СХНХХГ-ын дарга Д.Батмөнх нарын ёс зүйтэй холбоотой гомдлыг шалган ёс зүйн дүгнэлт гаргаж, Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлээ. -Төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчдын ёс зүйтэй холбоотой ёс зүйн зөрчлийг бүртгэж, байгууллагын веб сайтад улсын байцаагчийн кодоор мэдээлж байна.	7.1.11 7.2.3.
		“ñ çúéí äúðéì, журам болон Ёс зүйн хорооны үйл ажиллагааны талаарх мэдээллийг байгууллагын вэйб сайтад байршуулан, ёðäýä íëíí íëéóðüä èè тод мэдээлэх	Төрийн захиргааны албан хаагчийн ёñ çúétэй холбоотой äúðéì, журам болон МХЕГ-ын Ёс зүйн хорооны үйл ажиллагаа, бүрэлдэхүүний талаарх мэдээллийг байгууллагын веб сайтад байршуулан ёðäýä, íëíí íëéóðüä èè тод мэдээлж байна.	7.1.11 7.2.3.
		Төв, орон нутгийн МХБ-уудын Ёс зүйн хорооны тайлан, мэдээнд дүн шинжилгээ хийж, нэгтгэн боловсруулан, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлд хүргүүлнэ	Төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагуудын Ёс зүйн хороодын эхний хагас жилийн тайланг нэгтгэн боловсруулж, ёс зүйн зөрчлийн тухай дүн, мэдээг холбогдох журмын дагуу Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороонд yoszui@csc.gov.mn хаягаар хүргүүлсэн.	7.1.11
		Ёс зүйн зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ тооцож ажиллана.	Төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагуудын Ёс зүйн хороодод ирсэн нийт 23 улсын байцаагчийн ёс зүйтэй холбоотой зөрчлийг шалган тогтоож, улмаар 15 улсын байцаагчид сахилгын шийтгэл ногдуулж, нийтэд мэдээллэсэн.	7.1.11. 7.2.3.
11	Албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх	Албан тушаалтны шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт,	-Төв, орон нутгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын удирдлагаас Ёс зүйн хороодтой хамтран “Сахилга, хариуцлагыг сайжруулах сарын аян зохион байгуулах тухай” МХЕГ-ын даргын 2014 оны 44 дугаар тушаал, түүний	7.2.3.

	<p>арга хэмжээ авч ажиллана.</p>	<p>хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/ зохион байгуулна.</p>	<p>хэрэгжилтийг хангах ажлын удирдамжийн дагуу тодорхой шинэлэг ажлууд зохион байгуулсан. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> -Сүхбаатар аймгийн МХГ-аас ажилтнуудын ёс зүй сахилга хариуцлага, хувь хүний манлайллыг дээшлүүлэх зорилгоор нийт ажилтнуудыг хамруулан “Эрдэм шинжилгээний бага хурал” зохион байгуулж, 13 илтгэлийг өрсөлдүүлэн эхний 5 байрыг шагнаж урамшуулсан; -Сэлэнгэ аймгийн МХГ-ын Ёс зүйн хорооноос санаачлан “Албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах сарын аян зохион байгуулах тухай” А/06, “Ухаалаг төрийн зарчим хэлэлцүүлэг зохион байгуулах тухай” А/09, “Ёс зүйн сарын аян” А/12, улсын байцаагч нарын ажлыг сайжруулахад чиглэгдсэн “Үүрэг даалгавар өгөх тухай” А/46, “Ажлын цаг ашиглалтыг сайжруулах, ажлын цагаар цахим хуудас үзэхийг хориглох тухай” А/48-р тушаал зэрэг ажил сайжруулж сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогийн шийдвэрүүдийг газрын даргаар батлуулан хэрэгжилт үр дүнг тооцож ажилласан; -Дундговь аймгийн МХГ-аас “Авилгыг тэвчигч, ёс зүйтэй хамт олон” болох зорилт дэвшүүлж ажилтан бүрээр гарын үсэг зуруулж 11 үзүүлэлттэй сахилга хариуцлагын сертификат гардуулан энэхүү сертификатаа сар бүр дүгнэж зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэн ажилласан; -Баян-Өлгий аймгийн МХГ-аас аймгийн болон сумдын нийт 76 улсын байцаагчид “Сахилга хариуцлагыг сайжруулъя” сэдэвт зөвлөгөөнийг 2014 оны 02-р сарын 06-07-ны өдрүүдэд зохион байгуулан, ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх чиглэлээр хамт олноороо хэлэлцэн зөвшилцөж “Бид байгууллагаараа авилгагүй, ёс зүйтэй хамт олон” уриатай мэдэгдэл гаргаж бүх улсын /ахлах/ байцаагч, ажилчид гарын үсэг зурж самбарт ил байрлуулсан; -Архангай аймгийн МХГ-ын дарга аймгийн 28, сумын 51, нийт 79 улсын байцаагч тус бүртэй “Сахилга хариуцлага манлайлал”-ын гэрээг байгуулсан; -Баянхонгор, Дорнод, Увс аймгийн МХГ-аас бүх улсын байцаагч нарын дунд “Авилгын эсрэг хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын 	
--	----------------------------------	---	--	--

			<p>зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-аар асуулт хариултын “АХА” тэмцээн зохион байгуулсан;</p> <p>-Булган аймгийн МХГ-ын хамт олон “Авлига, хүнд сурталгүй, ёс зүйтэй хамт олныг төлөвшүүлэх мэдэгдэлд нийт ажиллагсад гарын үсэг зурж ил тодоор байршуулсан;</p> <p>-Дархан аймгийн МХГ-ын хамт олон “Авлигааһ аfaèè, õçia òòòàèàçé, ÿñ ççéòyé òàìò íèíûā ò°è°aøççéyō iûāyāāzē” гарын үсгүү зурж баталгаажуулан “Ô°òèéí àèààí òāāā+ийí ÿñ ççé”-í iûāyūèèèéí òàíāàòò ил тод àèéòшóóëсан;</p> <p>-Говь-Алтай аймгийн МХГ-аас улсын байцаагчдын өдөр тутмын сахилга хариуцлагыг үнэлж, дүгнэж, ажлын цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж байгаа байдалд хяналт тавих зорилгоор МХГ-ын даргын 2014 оны 02 дугаар сарын 06-ний өдрийн А/5 тоот тушаалаар “Сахилгын анхааруулах талон” хэрэглэх журмыг батлан хэрэгжүүлсэн;</p> <p>-Ховд аймгийн МХГ-аас “Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын дэвтэр хөтлөх, түүнд хяналт тавих журам” боловсруулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан;</p> <p>-Өвөрхангай аймгийн МХГ-аас “Байгууллагын үйлчилгээний стандарт”-ын төслийг боловсруулан, хамт олны хурлаар хэлэлцүүлсэн зэрэг нь зохих үр дүнгээ өгсөн байна.</p>	
		<p>Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд болон иргэдийн мэдээллийн дагуу илрүүлсэн авлигын зөрчлийг АТГ-т мэдээллэж, холбогдох арга хэмжээ авна.</p>	<p>Өвөрхангай аймгийн МХГ-ын дарга Х.Мөнхбат, Сүхбаатар аймгийн МХГ-ын дарга Б.Гантулга нарын ёс зүй, ашиг сонирхолын зөрчлийн талаар ирүүлсэн гомдлыг шалган дүгнэлт гаргасан. Дотоод хяналт шалгалтаар авлигын эсрэг хууль тогтоомж зөрчсөн байж болзошгүй гэж үзсэн нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга С.Даваасүрэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хилийн мэргэжлийн хяналтын газрын дарга Г.Адъяасүрэн, Эрсдэлийн үнэлгээ, удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Э.Мөнхөө, ургамал, хорио цээр, чанарын хяналтын улсын ахлах байцаагч Д.Довчинсүрэн, Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Гантулга нарын гаргасан зөрчлийн талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, хамтран ажилласан. /Холбогдох материалыг хавсаргав./</p>	<p>7.2.3.</p>
<p>12</p>	<p>Иргэдийн өргөдөл /санал,</p>	<p>Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах</p>	<p>Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлт мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж тус газраас 1800-1286 тусгай дугаарыг</p>	<p>7.1.14</p>

<p>мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгана.</p>	<p>нөхцөлийг бүрдүүлж 1286 тусгай утас болон санал хүсэлтийн хайрцаг, дэвтэр ажиллуулна. Засгийн газрын 1111 төвөөс шилжүүлсэн гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэнэ.</p>	<p>ажиллуулж, ирүүлсэн мэдээллийн хариуг www.inspection.gov.mn вэб сайт болон утсаар өгч үйлчилж байна. Түүнчлэн санал хүсэлтийн хайрцагийг ажиллуулж, иргэдийн санал, хүсэлтийг авч байна. МХЕГ-т 2014 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар нийт 1298 өргөдөл, гомдол ирсэн /1292 хариу шаардсан, 6 санал, талархлын шинжтэй/ байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд анхаарч ажилласны дүнд нийт өргөдөл, гомдлын 1235 буюу 95,6 хувийг зохих журмын дагуу шийдвэрлэж, хариу өгсөн бөгөөд 57 буюу 4,4 хувь нь шийдвэрлэх шатандаа байна.</p> <p>Засгийн газрын 11-11 төвөөс МХЕГ-т 2014 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар нийт 508 гомдол шилжүүлсэн байна. Засгийн газрын 11-11 төвд ирсэн гомдол мэдээллийн бүртгэл хөтлөн, холбогдох газар, хэлтэс, харъяа мэргэжлийн хяналтын байгууллагад шилжүүлэн ажиллаж, 446 гомдлыг шийдвэрлэсэн бөгөөд 62 гомдол нь шийдвэрлэх шатандаа явж байна.</p> <p>МХЕГ-ын 1800-1286 утсанд 2014 оны 11 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар байдлаар нийт 291 гомдол бүртгэгдсэн байна. Ирсэн гомдол, мэдээллийн бүртгэл хөтлөж, 255 гомдлыг шийдвэрлэсэн бөгөөд 36 гомдол нь шалгагдаж байна. Гомдлыг тухай бүр нь харъяа нэгжийн дарга нарт мэдэгдэн шийдвэрлүүлж ажилласан.</p>	
	<p>Өргөдөл, гомдол, албан бичиг хариуцсан ажилтны овог нэрийг албан тушаал, ажиллах журам, харилцах утасны хамт байгууллагын вэб сайтад байршуулна. Түүнчлэн МХЕГ-ын удирдах албан тушаалтнуудын зүгээс иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь гаргаж цахим хаяг, мэдээллийн самбарт байршуулна.</p>	<p>Өргөдөл, гомдол, албан бичиг хариуцсан ажилтны овог нэрийг албан тушаал, ажиллах журам, харилцах утасны хамт байгууллагын www.inspection.gov.mn вэб сайтад болон мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна. МХЕГ-ын удирдах албан тушаалтнуудын зүгээс иргэдийг тухай бүр хүлээн авч уулзаж байна.</p>	7.1.14
	<p>Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээг байгууллагын цахим хуудсанд тогтмол байршуулна.</p>	<p>Засгийн газрын 11-11 төв, МХЕГ-ын 1286 дугаарын утсанд ирсэн гомдол, мэдээлэл түүний шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг байгууллагын www.inspection.gov.mn вэб сайтад тогтмол байршуулж мэдээллэж хэвшсэн. Холбогдох</p>	7.1.14

			мэдээллийг вэб сайтын мэдээ, мэдээлэл хэсэг болон нүүрэн хэсгийн баруун хэсэгт тус тус байршуулсныг үзэх боломжтой.	
		Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл, мэдэгдлийн дагуу асуудлыг шалгаж, буруутай нь тогтоогдвол хариуцлага тооцож ажиллана.	Иргэн, байгууллагаас Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны дарга С.Баясгалан, Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Гантулга, Өвөрхангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Х.Мөнхбат нарыг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэж байгаа талаар мэдээлэл, хүсэлт ирүүлснийг Авлигатай тэмцэх газартай хамтран шалгасан. Шалгалтаар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Гантулга, Х.Мөнхбат нар мэдээлэлд дурьдагдсан ашиг сонирхлын зөрчил гаргаагүй болохыг тогтоосон бөгөөд хөрөнгө орлогын мэдүүлгээ буруу мэдүүлсэн Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны дарга С.Баясгаланд албан тушаалын цалингийн хэмжээг 3 сарын хугацаатай 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан.	7.2.2.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ⁱ Төлөвлөгөөнд тусгагдсан хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийн өмнөх шифр.

ⁱⁱ Хуулиар хүлээсэн үүргийн биелэлтээс гадна МХЕГ-аас хийж хэрэгжүүлсэн бүтээгдэхүүн.

Хавсралт 200 хуудас материалыг хүргүүлэв.